

Бүлэг, сэдэв:
Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн: он ... сар ... өдөр цаг
Дууссан: он ... сар ... өдөр цаг

Түүхийг хэрхэн судлах вэ?

1991 онд Альпийн нуруунд аялж явсан уулчид одоогоос 5200 жилийн өмнө амьдарч байсан эртний хүний цогцсыг олжээ. Цасан дороос илэрсэн энэ нууцыг тайлахаар эрдэмтэд яг л цагдаагийн мөрдөгч шиг уйгагүй судалсны үр дүнд хэн байсныг нь мэдсэн билээ. Тэд түүнийг Өтци гэж нэрлэсэн юм. Өтци нь 40 гаруй насны эрэгтэй хүн байсан бөгөөд шинэ чулуун зэвсгийн үед амьдарч байжээ.

У.Туяа нар. Түүх VI. УБ., 2019. т.5 Өтцигийн талаар дэлгэрүүлж уншаарай.

6.1a

1. Сурагчид аа! Өтцитэй уулзах боломж олдвол та нар ямар асуулт асуух вэ?

а. Та Альпийн нуруунд юу хийж явсан бэ? гэх мэт.

б.

в.

г.

6.1б

2. Сурагчид аа! Өтцигээс асуусан асуултынхаа хариуг хамтдаа олцгооё.

а. Өтци гэж хэн бэ?

.....
.....
.....
.....

б. Юу, юу үүрсэн байна вэ? Өтцид яагаад хэрэгтэй вэ?

.....
.....

в. Ямар хувцас өмссөн байна вэ? Өмссөн хувцаснаас үзвэл ямар ажил эрхэлдэг байсан бэ?

.....
.....
.....



“Өтци” хөндийгөөс 1991 онд олдсон “цасан доорх хүн” түүнийг сэргээсэн байдал

г. Гартаа юу барьсан байна вэ? Та үүний талаар юу мэддэг вэ?

.....
.....
.....

Бүлэг, сэдэв:
Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн: он ... сар ... өдөр цаг
Дууссан: он ... сар ... өдөр цаг

Түүхэн он тоололтой ажиллаж сурцгаая!

Өтцигийн амьдарч асан он цагийг тодорхойлоход бидэнд түүхийн он тооллын мэдлэг, чадвар хэрэгтэй билээ. Есүс Христийн мэндэлсэн өдрөөс он тооллыг эхлэн тоолох болсноор түгээмэл тоолол бий болсон. Загалмайтны шашны энэхүү тооллыг дэлхийн ихэнх улс оронд хэрэглэдэг учир нийтийн тоолол (НТ) гэдэг. НТ нь багаасаа их рүүгээ тоологдоно. Есүс Христ мэндлэхээс өмнөх үйл явдлуудыг ухрааж тоолох бөгөөд нийтийн тооллын өмнөх (НТӨ) тоолол гэж тэмдэглэнэ.

У.Туяа нар. Түүх VI. УБ., 2019. т.6 дэлгэрүүлж уншаарай.

Он тооллын шугам зурж сурцгаая!

Он тооллын шугам нь зүүнээс, баруун тийш чиглэсэн сум байна. Сумаар зурж буй нь цаг хугацаа “*өнгөрснөөс, одоо, ирээдүй рүү*” зогсолтгүй үргэлжилж буй гэсэн утга санааг илэрхийлж буй юм. Он тооллын шугамд “*Нийтийн тооллын өмнөх*”, “*Есүс Христ мэндэлсэн*”, “*Нийтийн тоолол*”, “*НТ 1 он*”, “*2021 он*” гэсэн тэмдэглэгээнүүдийг заавал тэмдэглэнэ. Тэмдэглэхдээ эхний үсгүүдийг томоор бичнэ. *Зурж үзүүлбэл,*

Он тооллын шугам:



6.2a

1. Өтци одоогоос 5200 жилийн өмнө намрын нэгэн орой нас барсан ажээ.
 - а) Өтци хэдэн онд нас барсан бэ?
 - б) Он тооллын шугам зурж, Өтцигийн нас барсан оныг тэмдэглээрэй.

Он тооллын шугам зурах хэсэг:

2. Дараах түүхэн үйл явдлуудын он цагийг тооцоолоорой. 6.26

- а) Өтциг 1991 онд Альпийн нуруунаас олсон билээ. Өтци хичнээн жил Альпийн нуруунд байсан бэ?
- б) НТӨ 50 он, НТ 50 оны аль хичнээн жилээр эртнийх вэ?

Дасгал ажиллах хэсэг:

а)

б)

Бүлэг, сэдэв:
 Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн: он ... сар ... өдөр цаг
 Дууссан: он ... сар ... өдөр цаг

Түүхийн эх сурвалж гэж юу вэ?

Хэрэв эртний хүмүүс өөрсдийнхөө тухай ямар ч ул мөр үлдээгээгүй бол бид тэдний тухай хаанаас мэдэх билээ? Тэдний ул мөрийг археологич, түүхч нар хайж олоод, судалгаа хийж бидэнд мэдээлдэг гэдгийг Өтцигөөс мэдэж авсан билээ. Эртний хүмүүсийн амьдралын ул мөрийг хадгалсан аливаа зүйлсийг “түүхийн эх сурвалж” гэнэ. Түүхийн эх сурвалжийг “эд өлгийн, бичгийн, аман” гэж ангилна.

У.Туяа нар. Түүх VI. УБ., 2019. т.9 дэлгэрүүлж уншаарай.

1. Түүхийн эх сурвалжид юу, юу орно гэж бодож байна вэ? **6.1в**

а. Эртний хүмүүсийн эдэлж хэрэглэж байсан багаж зэвсэг.

б.

в.

г.

е.


2. Түүхийн эх сурвалжуудын ангиллыг зөв эвлүүлж, зургийг ажиглан ангилал тус бүр дээр жишээнүүд гаргаарай. **6.3а**

1) Аман



а. ▲

2) Бичгийн




б.

3) Эд өлгийн



в.



- Бичигт хөшөө
 - Бичмэл хууль, цааз




Маш сайн ойлгосон дасгал, даалгавар	Эргэлзсэн дасгал, даалгаврууд	Тусламж хэрэгтэй даалгаврууд

Багшийн тэмдэглэл

Бүлэг, сэдэв: II. Өвөг түүхийн үе
Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн: он ... сар ... өдөр цаг
Дууссан: он ... сар ... өдөр цаг

Хүн хэрхэн үүссэн бэ?



У.Туяа нар. Түүх VI. УБ., 2019. т.12 дэлгэрүүлж уншаарай.

1. Зүй тогтлыг ажиглан даалгаврыг гүйцэтгээрэй. 6.3а

<p>1 400-500 см³</p>	<p>а Homo sapiens sapiens</p>	<p>I Анх чулууг ашиглан хийсэн хүн.</p>
<p>2 500-700 см³</p>	<p>б Australopithecus ...Хүн дүрст бич...</p>	<p>II орчим жилийн өмнөөс оюун ухаант хүн үүсэж хөгжив.</p>
<p>3 750-1250 см³</p>	<p>в Homo sapiens</p>	<p>III 400000 жилийн тэртээгээс гаргаж чаддаг болсон хүн.</p>
<p>4 1300 см³</p>	<p>г Homo erectus</p>	<p>IV Хүний анхны өвөг юм. Африк. тивд үүссэн.</p>
<p>5 1400 см³</p>	<p>д Homo habilis</p>	<p>V бол чухам өнөөгийн бидний өвөг дээдэс юм.</p>

ТҮЛХҮҮР ҮГ: ~~Хүн дүрст бич~~, Чадварлаг хүн, Босоо явагч хүн, Оюун ухаант хүн, Орчин үеийн хүн

~~Африк~~, багаж, 200000, ~~анхны~~, гал, Оюун ухаант хүн

Бүлэг, сэдэв: II. Өвөг түүхийн үе
Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн: он ... сар ... өдөр цаг
Дууссан: он ... сар ... өдөр цаг

Монголд хэзээ хүн анх амьдарч эхэлсэн бэ?

Эртний хүмүүс шинэ газар нутаг эзэмшиж, даян дэлхийд тархан суурьшсан билээ. Монгол нутагт 800000 жилийн өмнөөс босоо явагч хүн суурьшин амьдрах болжээ. Баянхонгор аймгийн Өлзийт сумын Нарийн голын бууц суурин нь одоогоос 8000000 жилийн өмнө, Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуй нь 730000 жилийн өмнө хамаарах бөгөөд Монгол нутаг дахь одоогоор мэдэгдэж буй чулуун зэвсгийн хамгийн эртний дурсгалт газрууд юм.

У.Туяа нар. Түүх VI. УБ., 2019. т.14-15 дэлгэрүүлж уншаарай.

1. Дасгал, даалгавруудыг ажиллаарай. 6.36

Зураг 1. Монголын хуучин чулуун зэвсгийн дурсгалт газрууд



а. Баянхонгор аймаг, Өлзийт сумын Нарийн голын дурсгалын түүхэн ач холбогдлыг тодорхойлоорой.

.....
.....
.....
.....



Зураг 2. Хойд цэнхэрийн агуйн хадны зураг (40000-12000 жилийн өмнө)

б. Ховд аймаг, Манхан сум “Хойд цэнхэрийн агуй”-н хадны зурагт юу юуг дүрсэлсэн байна вэ?

.....
.....
.....
.....

Эртний хүмүүс хэрхэн амьдардаг байв?

Хуучин чулуун зэвсгийн үед хүмүүс байгаль дээр байгаа зэрлэг ан амьтан, загас, идэж болохоор үр жимс, ус эрж хайн нэг газраас нөгөөд байнга нүүдэллэн амьдрах ба аж ахуйн хувьд “олзворлох” ба “түүвэрлэх” аж ахуй эрхэлж байлаа.

- Олзворлох бол (О), түүвэрлэх аж ахуй бол (Т) аль тохирохыг тэмдэглэнэ үү.

6.1a

- Их төлөв эмэгтэйчүүд хийнэ.

- Ихэвчлэн эрэгтэйчүүд хийнэ.

- Ан агнаж, загасчилна.

- Үр жимс түүнэ.



Маш сайн ойлгосон дасгал, даалгавар	Эргэлзсэн дасгал, даалгаврууд	Тусламж хэрэгтэй даалгаврууд

Багшийн тэмдэглэл

Бүлэг, сэдэв: II. Өвөг түүхийн үе
Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн: он ... сар ... өдөр цаг
Дууссан: он ... сар ... өдөр цаг

Газар тариалан ба мал аж ахуй хэрхэн үүссэн бэ?

НТӨ 8000 оны орчим буюу Шинэ чулуун зэвсгийн эхэн үед “мөстлөг” төгсөж, орчин үеийн хүн “газар тариалан” ба “мал аж ахуй” эрхлэх болсноор олзворлох, түүвэрлэх аж ахуйн үе дууссан билээ.

У.Туяа нар. Түүх VI. УБ., 2019. т.17-21 дэлгэрүүлж уншаарай.

1. Эхлээд мэдээллийг уншиж, дараа нь асуултад хариулаарай. **6.2a**

Сүүмчийн их мөстлөг 2 сая жилийн тэртээд эхлэв

Мөстлөгийн үед ургамал, амьтдын тоо цөөрсөн тул эртний хүмүүс олзворлох, түүвэрлэх аж ахуй эрхэлж, том удаан хөдөлгөөнтэй амьтдыг хавцал болон нүхэнд унагах, намагт шахах зэргээр агнаж хоол хүнсэндээ хэрэглэдэг байжээ.



Зарим амьтад мөхөв Зарим амьтад цөөрөв Зарим амьтад нүүв

Уур амьсгал, байгаль орчны дулаарал (НТӨ 8000 он)

Мөстлөгийн дараа цаг уур дулаарсан нь ургамал, амьтдын аймгийн тоо толгой олшироход эерэг нөлөө үзүүлжээ. Урьдын удаан хөдөлгөөнтэй, том биетэй амьтад цөөрсөн тул илүү хурдан, жижиг амьтдыг агнах шаардлага үүсчээ. Иймээс “жад”, “нум сум”, “урхи”, “загасны тор” зэрэг шинэ хөдөлмөрийн багаж, зэвсгүүдийг зохион бүтээжээ.



Зарим шинэ зүйлийн амьтад үүсэв Зарим амьтдыг гаршуулав

Мал аж ахуй хэрхэн үүсэв?

Өвгийн гүшүүд хоол хүнс хангалттай үед шархадсан амьтан, нялах төл зэргийг барьж, хашаана хорих замаар хүнд дасган зэрлэг амьтдыг гаршуулж эхлэв. Хүн төрөлхтөн анх нохойг эс тооцвол номхон бөгөөд махны гарц ихтэй тул “үхэр”-ийг гаршуулжээ.

Газар тариалан, гар урлал хэрхэн үүсэв?

Мөстлөгийн дараа орчин үеийн хүмүүс үр жимс, үндэс ногоо түүж явахдаа чийгтэй газар унасан үр ургаж соёлогийг ажиглажээ. Тэгээд газар сэндчиж үр суулгах болсноор газар тариалан үүсэв. Ирлэсэн чулуу, амьтны яс, эвэр зэргийг модны үзүүрт бэхлэн “сүх”, “зээтүү”, “халуур” гэх мэт хөдөлмөрийн багаж зэвсгүүдийг бүтээжээ.

Үр тариа нөөцлөх хэрэгцээнээс улбаалж, галд хийсэн шавар хатуурч бэхждэгийг ажиглан ваар сав хийх болсноор “гар урлал” үүсч, хөгжив.



Тариа, будаа



Гар урлалын бүтээгдэхүүн

а. Газар тариалан, мал аж ахуй үүсэхэд нөлөөлсөн хамгийн гол хүчин зүйл юу вэ?

.....
.....
.....

б. Байгаль, цаг уурын ямар өөрчлөлт нь хүний амьдралд сөрөг, ямар өөрчлөлт нь эерэг нөлөө үзүүлсэн бэ?

.....
.....
.....
.....

в. Мал аж ахуй хэрхэн, яагаад үүссэн байна вэ?

.....
.....
.....
.....

г. Газар тариалан ба гар урлал хэзээ хэрхэн үүсэв?

.....
.....
.....
.....

д. Мал аж ахуй ба газар тариалан, гар урлалтай уялдан шинээр бий болсон багаж зэвсгүүдийг нэрлээрэй.

.....
.....
.....

Бүлэг, сэдэв: III. Эртний иргэншил
Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн: он ... сар ... өдөр цаг
Дууссан: он ... сар ... өдөр цаг


Хүмүүс анх хаана, хэрхэн суурьшив?

НТӨ 8000 оны орчмоос томоохон гол мөрнүүдийн дагуу цөөн хүмүүс газар тариалан эрхлэн тэндээ суурьших болов. Аандаа газар тариалан эрхлэн суурьших хүмүүс олширч **“суурин тосгод”** бий болов. Суурин тосгод нь **“хот”** болон өргөжиж, хотуудаас хамгийн хүчирхэг нь оршин буй бүс нутагтаа ноёрхож **“хаант улс”**-уудыг байгуулжээ. Ийм маягаар үүссэн анхны хаант улсууд бол Тигр, Евфрат мөрний хөндийн Шүмер, Нил мөрний сав газрын Египет зэрэг улсууд юм.

У.Туяа нар. Түүх VI. УБ., 2019. т.23-27 дэлгэрүүлж уншаарай.

6.2a

Суурин иргэншил анх үүссэн газрууд



а. Суурин иргэншил хаана, хаана үүссэн байна вэ?

.....
.....
.....

б. Суурин иргэншил үүссэн газруудын адил төстэй талууд юу байна вэ? Тэнд суугчид ямар ажил эрхэлж байсан бэ?

.....
.....
.....

в. Суурин тосгоноос хэрхэн “хот улс”-ууд үүссэн бэ? Хот улсыг хэн захирч, ямар ямар хүмүүс түүнд захирагдах вэ?

.....
.....
.....

Бүлэг, сэдэв: III. Эртний иргэншил
 Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн: он ... сар ... өдөр цаг
 Дууссан: он ... сар ... өдөр цаг

Иргэншил хэрхэн хөгжив?

Иргэншил гэдэг нь хот суурин, нийгмийн анги давхарга, бичиг үсэг, төмөрлөг боловсруулалтад тулгуурлан үүсч, хөгжсөн нийгмийн зохион байгуулалт юм.

У.Туяа нар. Түүх VI. УБ., 2019. т.29-31 дэлгэрүүлж уншаарай.



- Бүдүүвч: 1-д буй он цаг, ойлголтыг (чулуу, зэс, хүрэл, төмөр) ашиглан он тооллын шугамд хөдөлмөрийн багаж зэвсгийн хөгжлийг тэмдэглээрэй. **6.2б**

Дасгал ажиллах хэсэг:

.....

.....

.....

.....

.....

.....

Бичиг үсгийн үүсэл

Анхны бичиг үсэг Шүмэрт НТӨ 3200-3100 оны үед үүсчээ. Бичиг үсэг нь хүмүүс засаг захиргаа, худалдааны хэргийг тэмдэглэх, бүртгэх, тооцоолох, түүнийгээ хадгалах хэрэгцээнээс үүдэн бий болжээ.

- “Түүх VI” сурах бичгийн 31-р талыг уншиж дараах бичиг үсгийн дурсгалууд хаанаас гаралтай, ямар бичиг үсгийн дурсгал болохыг тодорхойлоорой. **6.1а**



.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Маш сайн ойлгосон дасгал, даалгавар	Эргэлзсэн дасгал, даалгаврууд	Тусламж хэрэгтэй даалгаврууд	Багшийн тэмдэглэл
.....

Суурь боловсролын Түүхийн сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах “Бие даан ажиллах дэвтэр”-ийн сурагчдад өгөх зөвлөмж

Хүснэгт 1. Бие даан ажиллах дэвтэрт буй даалгаврын түвшин, тэмдэглэгээ:

Тэмдэглэгээ	Тайлбар
6.1a	6 - Анги
6.2a	1 – I түвшний даалгавар (улаан өнгө)
6.3a	2 – II түвшний даалгавар (шар өнгө)
	3 – III түвшний даалгавар (ногоон өнгө)
	a – Даалгаврын дугаар (Жишээ: a-1, б-2, в-3 гэх мэт)

Хүснэгт 2. Суралцахуйн замын зураглалтай ажиллах алхам:

I алхам:	Багшийн зөвлөсөн дасгал, даалгавруудаас эхлэн ажиллаарай.
II алхам:	Өөрийн хийж чаддаг болсон дасгал, даалгавруудыг тохирох түвшний өнгөөр будаарай.
III алхам:	Тухайн бүлгийн дасгал, даалагаврыг гүйцэтгэж эхэлсэн болон дуусгасан хугацааг заавал тэмдэглээрэй.
IV алхам:	Дасгал, даалгаврыг гүйцэтгэсний дараа өөрийгөө үнэлээрэй.
V алхам:	Багшаараа үнэлүүлж, өгсөн зөвлөмжийн дагуу сайжруулаарай.

Хүснэгт 3. Суралцахуйн замын зураглал:

	Бүлэг	I. Түүхийг хэрхэн судлах вэ?						II. Өвөг түүхийн үе				III. Эртний иргэншил			
		I		II		III	I	II	III	I	II				
VI анги	Түвшин	I		II		III	I	II	III	I	II				
	Дасгал	6.1a	6.1б	6.1в	6.2a	6.2б	6.3a	6.1a	6.2a	6.3a	6.3б	6.1a	6.2a	6.2б	
	Эхэлсэн													
	Дууссан													
	Өөрийн үнэлгээ													
	Багшийн үнэлгээ													

Жишээ нь, I. Түүхийг хэрхэн судлах вэ? бүлгийн 6.1a даалгаврыг гүйцэтгэсэн бол, суралцахуйн замын I. Түүхийг хэрхэн судлах вэ? бүлгийн, дасгал 6.1a нүдийг улаан өнгөөр будна.